

Монгол Улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаа

Засгийн газрын авлигатай тэмцэх чиглэлд хэрэгжүүлж байгаа ажлын талаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас бэлтгэн хүргүүлж байгаа 6 дахь дугаарын тойм мэдээг хүлээн авна уу. Тус мэдээнд:

- Улаанбаатар хотод 2023 оны 07 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монголын эдийн засгийн чуулган-2023” арга хэмжээний хүрээнд “Олон улсын индексийн үзүүлэлт ба Монгол Улсын өнөөгийн байдал” сэдвийн доор Монгол Улсын авлигатай тэмцэх индексийг сайжруулах, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоо сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлээ.
- Монгол Улс “Хувийн эрх зүйг ижилтгэх Ромын олон улсын хүрээлэн” (UNIDROIT)-гийн гишүүнээр элсэв.
- Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар тэргүүтэй төлөөлөгчид ИБУИНХУ-д ажлын айлчлал хийв.
- Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо Дэлхийн банкнаас зохион байгуулагдсан “Хөгжлийн төлөө авлигатай тэмцэх: Итгэлцлийг сэргээх нь” сэдэвт олон улсын хуралд оролцов.
- Эдийн засаг, хөгжлийн яам Дэлхийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэгж, мэргэжилтнүүдийн холбоо (WAPPP)-нд нэгдэв.
- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 26 дахь удаагийн жилийн хурал Канад Улсын Ванкувер хотод 2023 оны 7 дугаар сарын 9-14-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, тус хурлаар Монгол Улсын Явцын тайланг хэлэлцэж, ФАТФ-ын 40 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн үнэлгээтэй улс болов.



“Монголын эдийн засгийн чуулган-2023” амжилттай зохион байгуулагдлаа.

- Энэ жилийн Монголын эдийн засгийн чуулган “Монголд зочлох жил” уриан дор 2023 оны 07 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, Дэлхийн ханган нийлүүлэлтийн сүлжээ болон Бүс нутгийн худалдааны интеграцлалд Монгол Улсын гүйцэтгэх үүрэг, Монгол Улсын бизнес, хөрөнгө оруулалтын орчин, Монгол Улс бүс нутгийн бизнесийн төв болох зэрэг асуудлаар үндсэн хуралдаан, хэлэлцүүлэг болж, тэдгээрийн шийдлийн талаар хэлэлцлээ.
- Үндсэн хуралдаан, салбар хуралдааны зэрэгцээ “Олон улсын индексийн үзүүлэлт ба Монгол Улсын өнөөгийн байдал” сэдвийн хүрээнд Монгол Улсын авлигатай тэмцэх индексийг сайжруулах, төрийн ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулахад иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоо сэдвээр хэлэлцүүлгүүд өрнүүлээ.
- Хэлэлцүүлэгт Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Монгол Улсын Засгийн газрын авлигатай тэмцэх чиглэлд хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний хэрэгжилтийн талаар танилцууллаа. Тэрээр “Транспэрэнси Интернэшнл” олон улсын байгууллагаас гаргадаг Авлигын төсөөллийн индекс бол тухайн улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг илэрхийлдэг. Тэр утгаараа авлига, албан тушаалын гэмт хэрэг эдийн засагт хамгийн хор хөнөөлтэй. Бид авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, эрх зүйн орчныг сайжруулж байж гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжтой. Монгол Улсын Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтыг татах чиглэлд эрх зүйн орчныг сайжруулахад ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна. 2023-2024 оныг бид Авлигатай тэмцэх жил болгон зарлаж нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Цаашид ч хүний эрхийг хангах, нийтийн эрх ашгийг хамгаалж, эдийн засгийн үр өгөөжийг сайжруулахын төлөө үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэдгийг онцолсон юм.

Монгол Улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаа

Монгол Улс Хувийн эрх зүйг ижилтгэх Ромын олон улсын хүрээлэн (UNIDROIT)-гийн гишүүнээр элсэв.

- Монгол Улс 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Хувийн эрх зүйг нийцүүлэх Ромын олон улсын хүрээлэнгийн дүрэмд нэгдэн оров.
- Хувийн эрх зүйг ижилтгэх Ромын олон улсын хүрээлэн нь улс хоорондын хувийн эрх зүй, ялангуяа худалдааны эрх зүйг уялдуулах, харилцан нийцүүлэх арга барилыг судлах, улмаар улс орнууд хууль, эрх зүйн нийтлэг арга хэрэгсэл, зарчим, дүрмийг батлахад бэлтгэх зорилготой, Засгийн газар хоорондын бие даасан байгууллага бөгөөд одоогоор 63 улс тус байгууллагын гишүүнээр элссэн.
- Монгол Улсын гадаад харилцаа, худалдаа өргөжиж буй өнөө үед Монгол Улс тус хүрээлэнгийн гишүүнээр элсэх нь хувийн эрх зүйн шинэтгэлийг эрчимжүүлэх, цаашдын хөгжлийн чиглэлийг орчин үеийн, нийтлэг чиг хандлагад нийцүүлэн тодорхойлох, гадаад улс орнуудын эрх зүйн шинэтгэлийн сайн туршлагаас суралцах, нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж, цаашлаад Монгол Улсын иргэд, хувийн хэвшлийн байгууллагууд олон улсын хувийн эрх зүйн, ялангуяа худалдааны эрх зүйн хамтын ажиллагаанд үр дүнтэй оролцох, хувийн хэвшлийн бизнес эрхлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм.

Эдийн засаг, хөгжлийн яам Дэлхийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэгж, мэргэжилтнүүдийн холбоо (WAPPP)-нд нэгдэв.

- Эдийн засаг, хөгжлийн яам 2023 оны 07 дугаар сарын 06-ний өдөр Дэлхийн төр, хувийн хэвшлийн түншлэлийн нэгж, мэргэжилтнүүдийн холбооны бүрэн эрхт гишүүн болсныг мэдэгдэв.
- Тус холбоо нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн (ТХХТ) чиглэлээр төрийн болон хувийн хэвшлийн бүхий л оролцогч талуудыг нэгтгэсэн ашгийн бус олон улсын холбоо бөгөөд тус холбоонд төрийн ТХХТ-ийн нэгжүүд, корпорацийн хөрөнгө оруулагчид, санхүүгийн хөрөнгө оруулагчид, бүх салбарын мэргэжлийн зөвлөх байгууллага болон хувь хүмүүс багтдаг. Уг холбоо нь төр, хувийн хэвшлийн түншлэлийг худалдан авах ажиллагааны арга хэрэгсэл гэх ойлголтоос илүү өргөн хүрээнд хөгжлийн болон НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгод хүрэх хэрэгсэл гэж авч үздэг. Ингэснээр холбооны гишүүдийнхээ хүрээнд өргөн цар хүрээнд шилдэг туршлага, мэдлэгээ хуваалцах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлж, олон улсын жишигт нийцсэн, улсын хөгжлийн зорилтуудыг хангах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах боломжтой болох юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар тэргүүтэй төлөөлөгчид ИБУИНХУ-д ажлын айлчлал хийв.



- Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар тэргүүтэй төлөөлөгчид энэ оны 6 дугаар сарын 30-ны өдөр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсад айлчлав.
- Төлөөлөгчид Британийн Лорд Канцлер бөгөөд Хууль зүйн сайд Алекс Чоктой уулзаж, хууль, эрх зүйн салбарт хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх боломжийн талаар ярилцав.
- Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Монгол Улсад олон улсын санхүүгийн төвийг байгуулахыг зорьж буйтай холбогдуулан тус санхүүгийн төвд олон улсын стандартын дагуу Англи-Уэльсийн эрх зүйн тогтолцоог нэвтрүүлэхэд хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв. Түүнчлэн Монгол Улсын хууль зүйн салбарын боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн хуулийн боловсролыг нэмэгдүүлэх хүрээнд Британийн холбогдох хуулийн хүрээлэнтэй хамтарч ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлэв. Британийн талаас эдгээр асуудалд дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллахад бэлэн буйгаа мэдэгдэв.
- Их Британи улсад үйл ажиллагаа явуулдаг банк, санхүүгийн байгууллагуудын нэгдсэн холбоо болох "TheCityUK" байгууллагатай уулзалт хийж, Монгол Улсад олон улсын санхүүгийн төв байгуулахад хамтарч ажиллах боломжийн талаар ярилцав.

Монгол Улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаа



Дэлхийн банкны Авлигатай тэмцэх олон улсын хуралд оролцов.

- Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоогоор ахлуулсан Хууль зүй, дотоод хэргийн яамны төлөөлөл 2023 оны 06 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд Дэлхийн банкнаас зохион байгуулсан “Хөгжлийн төлөө авлигатай тэмцэх: Итгэлцлийг сэргээх нь” сэдэвт авлигатай тэмцэх олон улсын хуралд оролцлоо.
- Хуралд олон улсын байгууллага, хөгжлийн түншлэгч байгууллагууд, засгийн газар, төрийн байгууллагууд, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл оролцсон бөгөөд оролцогчид авлига нь иргэдийн ардчилсан институт, төрийн байгууллагуудад итгэх итгэлийг бөхөөж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг боомилж буй хүчин зүйл болж байгааг тэмдэглэж итгэлцлийг сэргээх, авлигатай тэмцэх ажлыг илүү үр дүнтэй болгоход оролцогч талуудын олон талт хамтын ажиллагаа чухал болохыг онцоллоо.
- Хурлын үеэр дэд сайд Б.Солонгоо “Төрийн үйлчилгээг хүргэхэд авлигатай тэмцэх нь” сэдэвт хэлэлцүүлэгт панелистаар оролцож, Монгол Улсын Засгийн газраас авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй “5Ш” ажиллагаа болон эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хийж буй ажлуудын талаар танилцууллаа.



Монгол Улс Санхүүгийн хориг арга хэмжээ хэрэгжүүлэх байгууллага (ФАТФ)-ын 40 зөвлөмжийг бүрэн хангасан улс боллоо.

- Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн 26 дахь удаагийн жилийн хурал Канад Улсын Ванкувер хотод 2023 оны 7 дугаар сарын 9-14-ний өдрүүдэд зохион байгуулагдлаа.
- Тус хуралд Монгол Улсын Явцын тайланг хэлэлцүүлж хамгаалах багийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Солонгоо ахалж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Татварын ерөнхий газрын төлөөллүүд оролцлоо.
- Хурлаар ФАТФ-ын 40 Зөвлөмжийн ашгийн бус байгууллагатай холбоотой “Зөвлөмж 8”-ын техник хэрэгжилттэй холбоотой Монгол Улсын Явцын тайланг хэлэлцэж баталлаа.
- ФАТФ-ын “Зөвлөмж 8”-д заасны дагуу ашгийн бус байгууллагыг терроризмыг санхүүжүүлэхэд ашиглах эрсдэлээс урьдчилан сэргийлж, холбогдох шаардлагыг хангаж ажиллах үүргийг гишүүн орнууд хүлээдэг. Тус хурлаар өмнө нь “хагас хэрэгжүүлсэн” үнэлгээтэй байсан “Зөвлөмж 8”-ыг “бүрэн хэрэгжүүлсэн” болгож техник хэрэгжилтийн үнэлгээг амжилттай ахуиллаа.
- Ийнхүү “Зөвлөмж 8”-ын үнэлгээг ахиулснаар Монгол Улс ФАТФ-ын 40 Зөвлөмжийг бүрэн биелүүлсэн үнэлгээтэй Ази, Номхон далайн орнуудаас анхны орон (Зөвлөмж 15-ыг шинэчилсэн үнэлгээгээр), дэлхийн улсуудаас 5 дахь орон боллоо.
- Тус хуралдаанаар Монгол Улсын энэхүү амжилтыг онцолж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, ажилд томоохон ахиц дэвшил гаргаж буйг тэмдэглэлээ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар ахалдаг бөгөөд төр, хувийн хэвшлийн байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан уялдааг шаарддаг.
- Монгол Улсын хувьд ФАТФ-ын 40 Зөвлөмжийг бүрэн хангасан үнэлгээ авсан нь Монгол Улс холбогдох шаардлагыг хууль тогтоомжид тусгаж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосныг олон улсаас баталгаажуулж буй явдал юм.